

“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН  
ШАГНАЛ, УРАМШУУЛЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, “Монгол Коосэн” технологийн коллежийн /цаашид “Сургууль” гэнэ/ хөгжил, стратеги төлөвлөгөөний биелэлтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн багш, ажилтан, оюутан, суралцагч, хамтран ажилладаг хувь хүн, байгууллагыг нэгдсэн бодлого, шалгуур үзүүлэлт, зохион байгуулалтын дагуу шагнал, урамшуулалд тодорхойлох, шалгаруулах, шагнал, урамшуулал олгох ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Сургуулийн шагнал, урамшууллын журам нь “Монгол Коосэн” технологийн коллежийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хэрэгжинэ.
- 1.3. Сургуулийн багш, ажилтан, оюутан, суралцагч, хамтран ажилладаг хувь хүн, байгууллагыг Монгол улсын цол хүртээх, Төрийн одон, медаль, Засгийн газрын шагналд тодорхойлж, нэр дэвшүүлэх болон тус сургуулийн шагналаар шагнах, урамшуулал олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. “Монгол Коосэн” технологийн коллежийн шагнал, урамшуулал

- 2.1. Тус сургуулийн шагнал, урамшуулал нь дараах төрөлтэй байна. Үүнд:
  - 2.1.1. Сургуулийн багш, ажилтанд дараах шагнал, урамшууллыг олгож болно.
    - “Оны шилдэг тэнхим”
    - “Оны шилдэг багш”
    - “Оны шилдэг ажилтан”
    - ТТДС-ийн эрдмийн зөвлөлийн шийдвэрээр хүндэт цол
  - 2.1.2. Сургуулийн оюутан, суралцагч, төгсөгчид дараах шагнал, урамшууллыг олгож болно.
    - “Оны шилдэг оюутан”
    - “Алтан цагийн эзэн”
    - “Тэнхимийн нэрэмжит шагнал”
  - 2.1.3. Тус сургуулийн багш, ажилтан сургуульдаа ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол дурсамж, үнэ бүхий зүйлээр шагнана.
  - 2.1.4. “Монгол Коосэн” технологийн коллежтой хамтран ажилладаг хувь хүн, байгууллагад шагнал, урамшуулал олгож болно.
  - 2.1.5. Үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан багш, ажилтанд сургуулиас мөнгөн болон бусад урамшуулал олгож болно.

## Гурав. Шагнал, урамшууллын болзол, шалгуур

### 3.1. Багш, ажилтанд тавигдах нийтлэг болзол, шалгуур

Шагнал, урамшуулалд нэр дэвшигч нь хамт олноо манлайлан, сургуулийн болон шинжлэх ухаан, технологи, боловсролын салбарыг хөгжүүлэх үйлсэд идэвх санаачилга, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж, эрхэлж буй ажилдаа тодорхой амжилт гаргасан, сахилгын ба ёс зүйн зөрчил гаргаагүй байна.

### 3.2. Тусгай болзол, шалгуур

Шагнал, урамшуулалд нэр дэвшигч нь 3.1-д заасан нийтлэг шалгуураас гадна нэр дэвшиж буй шагнал, урамшууллын тусгай болзол, шалгуурыг хангасан байна.

- 3.2.1. Монгол улсын цол, Төрийн одон, медаль, Засгийн газрын болон Нийслэлийн Бловсролын газар, НИТХ, НЗДТГ-ын шагналд нэр дэвшигч нь тухайн шагналтай холбоотой харилцааг зохицуулах журамд заасан болзол, шалгуурыг бүрэн хангасан байна.
- 3.2.2. **“Оны шилдэг тэнхим”** нэр дэвшигч нь сургалтанд шинэ арга, технологи нэвтрүүлдэг, багш нарын заах арга зүйн ур чадварыг байнга дээшлүүлж ажилладаг, бусад тэнхимээ үлгэрлэн манлайлдаг, сургалт, лаборатори, эрдэм шинжилгээний ажлын хувьд тэргүүний тэнхим байна.
- 3.2.3. **“Оны шилдэг багш”**-д нэр дэвшигч нь сургуульдаа тогтвор суурьшилтай ажиллаж, сургалтанд шинэ арга, технологи нэвтрүүлдэг, заах арга зүйн ур чадвараа байнга дээшлүүлж, бусад багш нарыгаа үлгэрлэн манлайлдаг, сургалт, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж буй үндсэн багш байна /Хавсралт 2/.
- 3.2.4. **“Оны шилдэг ажилтан”**-д нэр дэвшигч нь “Монгол Коосэн” Технологийн коллежийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийн шалгуурыг ханган ажиллаж, сургуулийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинэ ажил санаачлан, амжилттай хэрэгжүүлсэн, хамт олны дунд нэр хүндтэй үндсэн ажилтан байна /Хавсралт 3/.
- 3.2.5. Эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн ажлыг сайжруулах талаар идэвх зүтгэл, үр дүнтэй ажиллаж буй багш, ажилтанд ТТДС-ийн эрдмийн зөвлөлийн шийдвэрээр **хүндэт цол** олгож болно.

### 3.3. Оюутан, суралцагчийг шагнаж, урамшуулах:

#### 3.3.1. **“Оны шилдэг оюутан”**-д нэр дэвшигч нь /Хавсралт 1/:

- 3.3.1.1. Тухайн хичээлийн жилд 2 ба түүнээс дээш улирал дараалан А үнэлгээтэй суралцсан;
- 3.3.1.2. Сургууль, бүс нутгийн олимпиад, урлаг, спортын уралдаан, тэмцээн, ажил мэргэжлийн уралдаан, уран бүтээлийн үзэсгэлэнд сургуулиа төлөөлөн амжилттай оролцож байр эзэлсэн;
- 3.3.1.3. Анги, хамт олны дунд нэр хүндтэй, нийгмийн идэвхтэй, ёс зүйн зөрчил гаргаагүй.

#### 3.3.2. **“Тэнхимийн нэрэмжит шагнал”**-ыг сурлага, хүмүүжил, сахилга бат, ёс зүйн хувьд бусад оюутныг үлгэрлэн дагуулсан, суралцаж буй мэргэжлээрээ болон урлаг, спортын амжилт гаргасан оюутныг тэнхим сонгон шалгаруулна.

- 3.3.3. “Алтан цагийн эзэн” шагналд 1 улирлын турш хичээлийн цагийн хоцрогдолгүй суралцаж байгаа үлгэр жишээ оюутныг шалгаруулна.
- 3.4. Болзол хангасан оюутан, суралцагчийн тодорхойлолтыг анги удирдсан багш бичин, нотлох баримтын хамт оюутны албанд жил бүрийн 12-р сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.
- 3.5. Оюутны алба материалыг хүлээн авч, шалган захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулан, шийдвэрлүүлнэ. Шагналыг давхардуулан олгож болно
- 3.6. “Оны шилдэг оюутан”-ы зургийг нэг жилийн турш сургуулийн хүндэт самбарт тавьж, нийтэд алдаршуулна.

Дөрөв. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх, тодорхойлох

- 4.1. Багш нарын баяр, Шинжлэх ухаан, соёлын ажилтны өдөр, бусад мэргэжлийн болон тэмдэглэлт ойн өдөр, “Монгол Коосэн” Технологийн коллежийн ойгоор шагнал, урамшууллын шалгуурыг бүрэн хангасан, сургуульд ажиллаж байгаа үндсэн багш, ажилтан, оюутан, суралцагчдыг, мөн тус сургуулиас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнийг холбогдох шагнал, урамшуулалд нэр дэвшүүлнэ.
- 4.2. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх багш, ажилтан, оюутан, суралцагч, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнийг холбогдох нэгжийн хамт олны хурал, сургуулийн захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ. Хамт олны хурлын ирц 80%-иас дээш дэмжсэн тохиолд
- 4.3. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх багш, ажилтны ажил байдлын тодорхойлолтод нийт ажилласан хугацааны ажлын амжилт, үр бүтээл, хувь нэмэр, ёс зүйн байдал, ажил мэргэжлийн ур чадварын талаар үнэн зөв, тодорхой бичих ба бүтээлийн жагсаалт зэрэг холбогдох баримт бичгийг хавсаргана.
- 4.4. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх оюутан, суралцагчийн ажил байдлын тодорхойлолтод суралцах хугацаанд гаргасан сурлага, урлаг, спортын амжилт, суралцагчийн ёс зүйн байдлын талаар үнэн зөв, тодорхой бичиж холбогдох баримт бичгийг хавсаргана.
- 4.5. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх хамтран ажиллагч байгууллага, хувь хүний хувьд хамтран ажилласан хугацаанд сургуульд оруулсан оюуны болон материаллаг хувь нэмэр, үр дүнгийн талаар үнэн зөв, тодорхой бичих ба холбогдох баримт бичгийг хавсаргана.
- 4.6. Монгол улсын цол, Төрийн одон, медаль, Засгийн газрын болон Нийслэлийн Боловсролын газрын, НИТХ, НЗДТГ-ын шагналд нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт болон бүтээлийн жагсаалтад “Монгол Коосэн” Технологийн коллежийн захирал, “Монгол Коосэн” Технологийн коллежийн шагналд нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолтод холбогдох нэгжийн удирдлага гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна.

#### 4.7. Шагнуулахаар нэр дэвшигч нар дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

4.7.1. Монгол улсын цол, Төрийн одон, медаль, Засгийн газрын болон Нийслэлийн Боловсролын газрын, НИТХ, НЗДТГ-ын шагналд нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- Анкет (Монгол улсын цол, Төрийн одон, медаль, Засгийн газрын шагналд нэр дэвшигч холбогдох журамд заасан анкетыг бөглөнө)
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл
- Ажил байдлын тодорхойлолт
- Бүтээлийн жагсаалт
- Өмнөх шагналын хуулбар

4.7.2. “Оны шилдэг багш” шагналд нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ /Хавсралт 2/:

- Нэр дэвшигчийн танилцуулга
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Сургалт, арга зүйн зөвлөлийн хурлын тэмдэглэл
- Ажил байдлын тодорхойлолт
- Бүтээлийн жагсаалт (хийсэн төсөл, төхөөрөмж, хэвлүүлсэн бүтээл, ном, сурах бичиг, гарын авлага, хичээлийн үзүүлэн г.м. бусад материал)

4.7.3. “Оны шилдэг ажилтан” шагналд нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ /Хавсралт 3/:

- Нэр дэвшигчийн танилцуулга
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Тухайн жилд гаргасан амжилт, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүн
- Шууд харьяалах удирдлагын тодорхойлолт
- Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл

4.7.4. “Оны шилдэг оюутан” шагналд нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ /Хавсралт 1/:

- Нэр дэвшигчийн танилцуулга
- Оюутны сурлагын дүнгийн тодорхойлолт
- Оюутны талаарх анги даасан багшийн болон тэнхимийн эрхлэгчийн, Оюутны албаны тодорхойлолт
- Гаргасан амжилтын талаарх тодорхойлолт
- Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл

4.7.5. “Алтан цагийн эзэн” шагналд нэр дэвшигч

- Нэр дэвшигчийн танилцуулга
- Ирцийн мэдээ
- Оюутны талаарх анги даасан багшийн болон тэнхимийн эрхлэгчийн, Оюутны албаны тодорхойлолт

4.7.6. Тэнхимийн нэрэмжит шагнал

- Нэр дэвшигчийн танилцуулга

- Оюутны талаарх анги даасан багшийн болон тэнхимийн эрхлэгчийн тодорхойлолт

4.7.7. “Шилдэг түнш” шагналд нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- Тухайн байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллаж буй нэгжийн санал, дүгнэлт
- Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр
- Хамтын ажиллагааны бодитой үр дүнг илтгэх баримт бичиг

#### Тав. Шагнал, урамшууллыг шийдвэрлэх, олгох

- 5.1. Монгол улсын цол, Төрийн одон, медаль, Засгийн газрын шагнал, “Монгол Коосэн” Технологийн коллежийн шагнал, урамшуулалд нэр дэвшигчдийн бүрдүүлбэл зохих баримт бичгийн бүрдүүлэлтэд тэнхимийн эрхлэгч, нэгжийн удирдлага хяналт тавьж, сургуулийн захирлын дэргэдэх зөвлөл/сургалт, арга зүйн зөвлөлөөр хэлэлцэнэ.
- 5.2. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх санал, холбогдох баримт бичгийг тэмдэглэлт ой, баярын өдөр болохоос 1 сараас доошгүй хугацааны өмнө холбогдох алба, нэгжид ирүүлнэ.
- 5.3. “Оны шилдэг оюутан” шагналд нэр дэвшигчийг тэнхимээс ирүүлсэн саналуудыг нэгтгэн үзэж, Сургалтын алба, Оюутны албатай хамтран сонгон шалгаруулж, Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 5.4. Монгол улсын цол, Төрийн одон, медаль, Засгийн газрын шагнал, “Монгол Коосэн” Технологийн коллежийн “Оны шилдэг багш”, “Оны шилдэг ажилтан” шагналд нэр дэвшигчийн шалгаруулалтыг захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 5.5. Сургуулийн захиргаа, аж ахуйн алба нь тэнхим, нэгжийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол улсын цол, Төрийн одон, медаль, Засгийн газрын шагналд нэр дэвшигчдийн баримт бичгийг эцэслэн бэлтгэж, хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан холбогдох байгууллагад хүргүүлж, эргэх холбоотой ажиллана.
- 5.6. “Монгол Коосэн” Технологийн коллежийн шагнал, урамшууллыг сургуулийн тэнхим, нэгжийн санал, дүгнэлт болон захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Захирлын тушаалаар олгоно.
- 5.7. Энэхүү журмын дагуу шагнал, урамшуулалд тодорхойлогдож, шагнагдсан багш, ажилтанд шагналд дагалдах мөнгөн урамшууллыг олгоно.
- 5.8. Шагнал, урамшуулалд дагалдах мөнгөн зардлыг сургуулийн урамшууллын сангаас санхүүжүүлнэ.
- 5.9. Шагналд дагалдах мөнгөн урамшуулал дараах хэмжээтэй байна.
  - А. Төрийн дээд болон одон, медаль, Засгийн газрын шагнал, БСШУСЯ, Нийслэлийн боловсролын газрын шагналыг дагалдах мөнгөн урамшууллыг холбогдох журмуудыг үндэслэн олгоно.
  - Б. “Монгол Коосэн” Технологийн коллежийн шагнал, урамшуулал:

“Оны шилдэг тэнхим” – 1,000,000 төгрөг

“Оны шилдэг багш” – 1,000,000 төгрөг

“Оны шилдэг ажилтан” – 1,000,000 төгрөг

“Оны шилдэг оюутан” өргөмжлөл – 200,000 төгрөг, Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт нэр дэвших эрх

“Алтан цагийн эзэн” өргөмжлөл – бэлэг дурсгал, “Сакура сайэнс”, “Женесис” хөтөлбөрт нэр дэвших эрх

Тэнхимийн нэрэмжит шагнал – бэлэг дурсгал

*/энэхүү хэсэгт 2022 оны 10-р дугаар сарын 03-ны өдрийн А/23 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан/*

- 5.10. “Шилдэг түнш” шагналаар шагнуулах байгууллага, хувь хүнд өргөмжлөл олгож, мөнгөн шагналаар шагнана. Шагналыг дагалдах мөнгөн урамшууллын хэмжээг захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 5.11. Сургуулийн захиргаа нь “Монгол Коосэн” Технологийн коллежийн хэмжээнд шагнагдсан болон шагнуулахаар нэр дэвшигдэж байсан багш, ажилтан, оюутан, суралцагчдын, түншлэгчийн нэгдсэн мэдээллийн сантай байна.

Оны шилдэг оюутанд нэр дэвшигчийн анкет, танилцуулга

1. Ямар шагналд: .....
2. Нэр: .....
3. Тэнхим: ..... Анги: .....
4. Сурлагын голч: ..... / тухайн оны /
5. Эрдэм шинжилгээ, илтгэл, судалгаа, хийсэн ажил болон хамтран оролцсон байдал:  
.....  
.....
6. Сурлагын амжилт /сүүлийн 2 жилийг оролцуулан бичих/: .....
7. Олон нийтийн ажил, нийгмийн идэвх: .....
8. Шилдэг суралцагчид нэр дэвших үндэслэл: .....
9. Нэр дэвшүүлсэн: / Тэнхим, анги, хамт олон, клубын хурлын тэмдэглэл хавсаргах /
10. Хавсралт бичиг баримт, хуулбарууд
11. Ямар шагнал авч байсан /Тус сургуульд суралцаж байх хугацаанд/:  
.....  
.....

Оны шилдэг багшид нэр дэвшигчийн анкет, танилцуулга

1. Ямар шагналд: .....
2. Нэр: .....
3. Тэнхим: ..... Даасан анги: .....
4. Оюутны амжилт, эрдэм шинжилгээ, илтгэл, судалгаа, бүтээлийн болон хийсэн ажил, хамтран оролцсон байдал:  
.....  
.....
5. Олон нийтийн ажил, нийгмийн идэвх: .....
6. Шилдэг багшид нэр дэвших үндэслэл: .....
7. Нэр дэвшүүлсэн: / Тэнхим, анги, хамт олны хурлын тэмдэглэл хавсаргах /
8. Хавсралт бичиг баримт, хуулбарууд
9. Ямар шагнал авч байсан /Тус сургуульд ажиллаж байх хугацаанд болон өмнө/  
.....  
.....

Оны шилдэг ажилтанд нэр дэвшигчийн анкет, танилцуулга

1. Ямар шагналд: .....
2. Нэр: .....
3. Нэгж: .....
4. Хийж гүйцэтгэсэн, сайжруулсан ажил, шинэ санаачилга болон хамтран оролцсон байдал:  
.....  
.....
5. Олон нийтийн ажил, нийгмийн идэвх: .....
6. Шилдэг ажилтанд нэр дэвших үндэслэл: .....
7. Нэр дэвшүүлсэн: / Нэгж, хамт олны хурлын тэмдэглэл хавсаргах /
8. Хавсралт бичиг баримт, хуулбарууд
9. Ямар шагнал авч байсан /Тус сургуульд ажиллаж байх хугацаанд болон өмнө/:  
.....  
.....